2022 он 07 сар 07 өдөр Дугаар

№	Жолоочийн нэр	Хэмжих нэгж		Тээвэрлэж буй ачаа		Нэгжийн үнэ	Нийт үнэ
		тонн	кг	хуурай	шингэн		
	Сайнаа			✓		150,000	

Санамж: 1 хувийг тухайн газартаа
2 хувийг нэвтрэх цэгт
3 хувийг хог хаягдлын цэгт хураалгана

Нэвтрэх цэг: 10 цаг 00 минут

Хүлээн авсан жолооч:
Гэр буудлын менежер: *М.Х. Дорно*

HUVSGUL хог хаягдал, бохир тээвэрлэх
ХЯНАЛТЫН ХУУДАС

2022 он 7 сар 8 өдөр Дугаар

№	Жолоочийн нэр	Хэмжих нэгж		Тээвэрлэж буй ачаа		Нэгжийн үнэ	Нийт үнэ
		тонн	кг	хуурай	шингэн		
	Ансанхүү ХОВ 9302			✓		80,000	

Санамж: 1 хувийг тухайн газартаа
2 хувийг нэвтрэх цэгт
3 хувийг хог хаягдлын цэгт хураалгана

Нэвтрэх цэг: 17 цаг 30 минут

Хүлээн авсан жолооч:
Гэр буудлын менежер: *М.Х. Дорно*

Хог хаягдал зайлуулсан бүртгэл, хяналтын хуудас

HUVSGUL хог хаягдал, бохир тээвэрлэх
ХЯНАЛТЫН ХУУДАС

2022 он 7 сар 22 өдөр Дугаар

№	Жолоочийн нэр	Хэмжих нэгж		Тээвэрлэж буй ачаа		Нэгжийн үнэ	Нийт үнэ
		тонн	кг	хуурай	шингэн		
	Н.Сайтбаяр			✓		150,000	

Санамж: 1 хувийг тухайн газартаа
2 хувийг нэвтрэх цэгт
3 хувийг хог хаягдлын цэгт хураалгана

Нэвтрэх цэг: 18 цаг 15 минут

Хүлээн авсан жолооч:
Гэр буудлын менежер: *Н.Сайтбаяр*



“Гурван-Эрдэнэ” жуулчны баазын 2022 оны Байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Арга хэмжээний хэрэгжилт, биелэлт
1.	Хөрсний хими, физикийн үзүүлэлт-Агрохимийн шинжилгээ	2 – Жуулчны бааз 1 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулсан. Энэ хугацаанд цөөн тооны амрагч, жуулчдад үйлчилсэн бөгөөд жуулчны баазын талбайд хөрс, усны шинжилгээ хийгдээгүй болно.
2.	Ундны усны бүрэн шинжилгээ	

Cl ⁻	42.60	1.20	8.80	Na ⁺ +K ⁺	239.88	10.43	76.49
SO ₄ ²⁻	0.21	9.85	72.21	NH ₄ ⁺	0.20	0.01	0.08
NO ₃ ⁻	4.25	0.07	0.50	Ca ⁺⁺	39.68	1.98	14.52
NO ₂ ⁻	0.01	0.00	0.00	Mg ⁺⁺	14.59	1.20	8.80
CO ₃ ²⁻	38.40	0.64	4.69	Fe ⁺⁺	0.10	0.00	0.03
HCO ₃ ⁻	114.72	1.88	13.79	Fe ⁺⁺⁺	0.20	0.01	0.08
Дүн	200.18	13.63	100.00	Дүн	294.65	13.63	100.00

Энэхүү ус нь натри, калийн катион давамгайлсан сульфатын бүлгийн ус байна.

Хүснэгт 15. Усны химийн задлан шинжилгээний дүн (Хөвсгөл нуур)

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	МГ/ЭКВ	МГ/Л	МГ-ЭКВ/Л		МГ/ЭКВ	МГ/Л	МГ-ЭКВ/Л
Cl ⁻	14.06	0.40	7.91	Na ⁺ +K ⁺	41.19	1.79	35.76
SO ₄ ²⁻	0.07	3.15	62.92	NH ₄ ⁺	0.30	0.02	0.33
NO ₃ ⁻	3.65	0.06	1.18	Ca ²⁺	37.27	1.86	37.15
NO ₂ ⁻	0.08	0.00	0.03	Mg ²⁺	16.29	1.34	26.76
CO ₃ ²⁻	0.00	0.00	0.00	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃ ⁻	85.43	1.40	27.96	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	103.28	5.01	100.00	Дүн	95.06	5.01	100.00

Энэхүү ус нь натри, кальци, магни, калийн катион давамгайлсан сульфатын бүлгийн ус байна. Усны шинжилгээний дүнгээс ажиглахад Хөвсгөл нуурын усны химийн найрлага гол ионуудын харьцаанд мэдэгдэхүйц өөрчлөлт үгүй, тогтвортой шинжтэй, катионоос кальцийн ион зонхилсон, анионоос гидрокарбонатын ион дангаараа зонхилсон, зөөлөн, цэвэр, 1-р төрлийн усны ангилалд хамаарагдаж байна.

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСЭН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Гол зорилт	Арга хэмжээний хэрэгжилт, биелэлт
1	Дотоод хяналт сулрах, баримт бичиг эмх цэгцгүй байх	<p>2</p> <ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалтай холбоотой семинар, уулзалтад удирдлагын зүгээс оролцож, төр захиргааны байгууллалтаар хамтран ажиллаа. Орон нутгийн хөгжилд бодитой хөрөнгө оруулалт хийж. 2022 онд баяр наадмын болон гавьяатын үйл ажиллагаанд нийт 400 000 төгрөг хандивлав. - Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд дотоод хяналт тавьж, анхаарч ажиллав. - Байгууллагын дотоод журмыг сайжруулан дотоод хяналтыг тавьж ажиллав. - Жуулчны баазын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг сайжруулан ажилчдыг хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллуулав. Орон нутгийн тодорхой хувийн ажилгүй, орлогогүй иргэдийг ажлын байраар ханган ажиллаа. Үүнд: Ренчинлхүмбэ сумаас жуулчны баазын хогийг ангилан ялгах, ачиж, зайлуулах ажилд орон тооны хүн ажиллуулав. Мөн үйлчилгээ, эргүүл пост, сайн дурын байгаль хамгаалагчийн ажилд зуны амралттай байгаа оюутан залуучуудыг гэрээгээр хөдөлмөр эрхлүүлжээ. - Хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллав. Нарийн ногооны хүлэмжид салатны навч ургуулан амрагчдын хоол хүнсэнд хэрэглэв. - Ковид-19 цар тахлын нөхцөл байдал суларсан хэдий ч Коронавирус ковид-19 халдварын омикрон ва4, ва5 дэд хувилбараас урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйжүүлэлт болон бүртгэлийн цэгийн үйлчилгээг тогтмол хийж ажиллаа. - Хөвсгөл эрчим хүчний газарт цахилгааны төлбөрийн бүрэн төлж барагдуулав. (Төлбөрийн баримтыг доор оруулав).

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг баталгаажуулсан зураг

ХААН БАНК Огноо/Date: 2022-09-19 10:19:29

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын /Journal No: 4530522

Сэтгэлийн огноо/Spelled Date: 2022/09/19

Др	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	Дүн/Amount	Ханд/Rate
	5022987244	Турван-Эрдэнэ НҮӨН ЛХААГА ЦЭГЭНЦӨРЖ	200,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name Хаан Банк	200,000.00 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name		
	SB8114347	НҮӨН НЭМСҮҮЭЖ ПУУЦЭДӨРЖ		

Гүйцэтгэний утга/Transaction description
ХӨВСГӨЛ АЯМАГ АЯМАГ ЭРДЭНЭ СМХ ЭДТГ ХАНДИВ ЛГВЭЭЯАТ/

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйцэтгэний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, төсөл/branch/branch: _____

Гарын үсэг/Signature: _____

Тамга/Stamp: _____

Сангийн сайдын 2017 оны
12 дугаар сарын 5-ны өдрийн
347 тоот тушаалын хавсралт

БЭЛЭН МӨНГӨНИЙ ОРЛОГЫН БАРИМТ

Дугаар _____ 2022 он 7 сар 1 өдөр

Байгууллагын нэр _____
хүлээн авсан

Мөнгө тушаагч _____ ажилтан
Турван-Эрдэнэ МБ
овогтой _____ -нээс

Гүйцэтгэний утга _____
Хоёр хонгорин тасар

Тушаасан мөнгөний дүн _____ төгрөг 00 мөнгө
Хоёр зуун мянган төгрөг

Хавсаргасан баримт _____

Тэмдэг _____

Дарга _____
Нягтлан бодогч _____
Хүлээн авсан _____
Мөнгө тушаагч _____

Орон нутагт оруулсан хандив



ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000002496569976220822000099545110

Борлуулагчийн: :

ТТД: 2496569

НЭР: ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ

Хаяг: Монгол, Хөвсгөл, Мөрөн, 8-р баг, 3 байр, 3 тоот

Утас: 70382328, 70382328, 70382328

Банкны нэр:

Банкны дансны дугаар:

Огноо: 2022-08-22

Худалдан авагчийн:

ТТД: 2615843

НЭР: ЦЭЭГ

Хаяг: Монгол, Улаанбаатар, Сүхбаатар, 8-р

хороо, Төрийн өмчийн 11-р байр, 405

Утас: 99138073, 99138073

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Дараа төлөх хог тв хураамж	91	ш	1.00	0.00	0.00
2	Дараа төлөх хэрэглээ	92	ш	1.00	316,550.00	316,550.00
Бараа, ажил үйлчилгээний үнэ:						287,772.73
Нэмэгдсэн өртгийн албан татвар:						28,777.27
Нийслэл хотын албан татвар:						0.00
Нийт дүн:						316,550.00



Тамга

Хүлээн авсан:

(гарын үсэг)

(нэр)

Хүлээлгэн өгсөн:

(гарын үсэг)

(нэр)

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 6455653

Системийн огноо/System Date: 2022.09.29 10:45:34

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5022715361	Б****А ГАРАМХАНД	63,650.00 MNT	1.00
/ Жаран гурван мянга зургаан зуун тавин төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name	Дүн/Amount	Ханш/Rate
	05	Хаан банк	63,650.00 MNT	1.00
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	5890039297	ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ		

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-9071507 ЦЭЭГ ХХК

Цахилгааны төлбөрийн баримт



“Гурван-Эрдэнэ” жуулчны баазын 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

8. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1		2	3	4	5	6	7
1.	Хөвсгөл аймгийн БОАЖГ	БОМТ-ний биелэлтийн тайланг хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.	Тухайн жилийн БОМТ-г БОНХ-ийн сайдын 2019.10.29-ний өдрийн А/618 тоот тушаалын 3-рхавсралтаар батлагдсан БОМТ-ний биелэлтийг тайлагнах агуулгыг хамруулна.	11-р сарын 01-ний дотор	Үйл ажиллагааны зардал	ЦЭЭГ ХХК-ийн захирал, жуулчны баазын менежер, хариуцсан албан тушаалтан	Хөвсгөл аймаг, Мөрөн ЗДТГ
2.	Хөвсгөл аймгийн 3Д-ын томилсон ажлын хэсэг ¹	Газар дээр нь дүгнэнэ.		11 дүгээр сарын 30-ны дотор	Үйл ажиллагааны зардал	ЦЭЭГ ХХК-ийн удирдлага, төлөөлөл	Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Гурван-Эрдэнэ жуулчны бааз
3.	Ерөнхий үнэлгээ хийсэн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ)	БОМТ-ний биелэлтийн талаар тайлан болон дараа жилийн БОМТ төлөвлөгөөг хэвлэмэл болон CD хэлбэрээр хүргүүлнэ.		12-р сард багтаах /үйл ажиллагаа эхлэхийн өмнө/	Үйл ажиллагааны зардал	ЦЭЭГ ХХК-ийн захирал, жуулчны баазын менежер	Улаанбаатар хот БОАЖЯ

¹ Ажлын хэсэгт аймаг, ... байгаль орчны газрын дарга, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч, сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн, сум, ... байгаль орчны хяналтын улсын байцаагч, тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч, нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл орно. А/618 журмын 4.4-т

ДУГНЭЛТ

2022 он өмнөх жилийг бодвол Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалт буурч, аялал жуулчлал сэргэх хандлага ажиглагдаж дотоод, гадаадын жуулчдын ирэх урсгал нэмэгдсэн жил болов.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын гүйцэтгэлд удирдлагын зүгээс анхаарлаа хандуулж, жуулчны баазын тохижилтын ажлыг нэн түрүүнд тавьж барилга байгууламж, гэр сууц, урц, хоолны газар, гал тогоо, ариун цэврийн байгууламжийн өнгө үзэмжийг сайжруулж 40 м явган хүний зам модон зам тавих, ажилчдын байрны өргөтгөл, баазынхаа эргэн тойрны хашаа хөцөөг шинэчлэх, намгархаг хөрсний ус зайлуулах хоолой шуудуу татах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

Энэ зун аялал жуулчлалын улиралд /6, 7 сард/ Ренчинлхүмбэ, Улаан – Уул, Мөрөн, Хатгал, Алаг-Эрдэнэ сумдын 10 гаруй оюутан залуучууд, иргэдийг хөдөлмөрийн түр гэрээгээр жуулчны баазын тохижилт болон үйлчилгээний ажилд ажиллуулсан нь орон нутгийн тодорхой хувийн иргэдийн амьжиргаа, өрхийн орлого, сургалтын төлбөрт зэрэг нэмэр болсон гэж үзэж байна.

Үйл ажиллагааны хугацаанд жуулчны баазын хог хаягдлыг ангилан ялгах, ачиж, зайлуулах ажилд орон тооны 1 хүн ажиллуулж, улмаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 1 гэр бүлийн 2 хүнийг хатуу, шингэн хаягдал зайлуулах ажлыг хариуцуулан цалинжуулсан. Ингэснээр өрхийн орлого нэмэгдэхээс гадна хог хаягдал орчинд тархах улмаар бохирдол үүсгэхээс сэргийлсэн. Мөн эх үүсвэр дээрх хог хаягдлын хэмжээг багасгаж, хоёрдогч түүхий эдийг цуглуулагч хуулийн этгээдэд нийлүүлж байна.

Аймгийн БОАЖГ, Мэргэжлийн хяналт, Онцгой байдал, Хатгал тосгоны захирагчийн алба, Хөвсгөлийн УТХГ-ын захиргаанаас зохион байгуулсан /6 сард/ сургалт семинараар өгсөн зааварчилгааны дагуу жуулчны баазын ажилчдад сургалт зохион байгуулж үйлчлэгч, тогооч, хөтөч, харуул хамгаалалтын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журам, ажилтнуудын дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Жуулчны баазын 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллав. Үүнд:

- Ус ашиглах гэрээг Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-тай шинэчлэн байгуулж, цэвэр ус ашигласны болон ус бохирдуулсны төлбөр, ТХГН-т газар ашигласны төлбөрийг төлж, Хөвсгөлийн татварын хэлтэстэй тооцоо нийлсэн болно.
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хамтран ажиллах гэрээг эрх бүхий Хүн байгаль бүлгийн ахлагч Хог хаягдал, олон нийтийн байцаагч Ж.Сайнбаяртай шинэчлэн байгуулж, гэрээний дагуу тогтмол хугацаанд хатуу хог хаягдлаа ачиж зайлуулсан. Бүртгэлийг хяналтын хуудсаар баталгаажуулав. Үйл ажиллагааны явцад нийт 3 удаа хатуу хог хаягдлаа ачиж зайлууллаа. Үүнд 380 000 төг зарцуулав.
- Энэ жил хог хаягдлын менежментийг сайжруулахад онцгой анхаарч ажилласны үр дүнд Хүн байгаль бүлгэм, Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ, Хөвсгөлийн УТХГ-аас өндөр үнэлэлт авсаныг тэмдэглэж байна.

- Бохир ус ачиж зайлуулах гэрээг Олимп жуулчны баазын Байгаль эрхэс ХХК-тай байгуулж, хяналтын хуудсаар баталгаажуулан ажиллаа. Үйл ажиллагааны явцад нийт 7 удаа, 35 тн бохир ус соруулуулж, үүнд 1 950 000 төг зарцуулсан.
- Манай жуулчны бааз нь ариутгал халдваргүйжүүлэлтийг аймгийн Ган өрлөг ХХК-аар хийлгүүлэх гэрээ байгуулж, ахуйн хортон шавж, мэрэгч устгалыг хийлгэж, бохирын цооног, ариун цэврийн байгууламж, хогийн цэгт ариутгал халдваргүйтгэлийг хийлгэсэн болно.
- Орчны тохижилт, хөрс, ургамал хамгаалахад анхаарч жуулчны баазын үйл ажиллагаа эхлэх болон оргил ачааллын үед Хөцөө хашааны гадна доторх талбай, нуурын эрэг дагуух хог хаягдлыг 7 хоног бүр цэвэрлэж, хог хаягдлыг ачиж зайлуулсан. Мөн Усны хамгаалалтын бүс, ил задгай гал түлэх, бие засах, майхан барьж буух, нуурын усанд машин болон хувцас угаахыг хориглох, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гэх мэт тэмдэг тэдэглэгээ байршуулан ирсэн жуулчдад зөвлөмж өгч, оргил ачаалалтай үед сайн дурын байгаль хамгаалагч, өөрийн ажилчдаас эргүүл пост гарган ажиллуулсан нь үр дүнтэй боллоо.
- Манай жуулчны бааз нь Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгоны захирагчийн алба, Хөвсгөлийн УТХГ-ын захиргаатай байнга хамтран ажиллаж, сум орон нутгийн түүхт ой, баяр наадам, ахмадын байгууллага, төсвийн байгууллагуудад хандив тусламж үзүүлж ирсэн ба 2022 онд Хатгалын улсын баяр тэмдэглэх арга хэмжээ, Алаг-Эрдэнэ сумаас төрсөн гавьяатуудын хүндэтгэлийн арга хэмжээнд мөнгөн тусламж үзүүлсэн.
- Хатгал тосгоны цагдаагийн тасаг, Онцгой байдлын албанаас өгсөн удирдамж чиглэлийн дагуу гэмт хэрэг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх тодорхой ажлуудыг хийж, ирсэн жуулчид, амрагчид болон тэдний машин унааг бүртгэлжүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар санамж зөвлөмж өгч аялагч жуулчдын дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг /Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 109 дүгээр тогтоол / танилцуулж, барилга байшин объектуудыг камержуулж, харуул хамгаалалтыг сайжруулснаар элдэв гэмт хэрэг зөрчил бүртгэгдээгүй болно.

Улсын Тусгай Хамгаалалттай газар нутагт газар ашиглах гэрээний үүргээ 95 хувьтай сайн биелүүлж ажиллаа.

Санал:

Тойлогтын шилээс Чөчүгийн харуулын пост хүртэл /10 км/ байгалийн замыг цогцоор нь сайжруулж машины, дугуйн, явган хүний замыг шийдэж, авто машины зогсоолуудыг барьж байгуулах ажлыг хурдавчлах хэрэгтэй байна. Дэд бүтцийг Тойлогтоос дээш маш сайн шийдэж, Чөчү уулын / д.т.д 2640 м / орой дээр гарч Хөвсгөл нуурыг бүхэлд нь харах дотоод гадааддын жуулчдын урсгал эрс нэмэгдэхээр байгааг анхаарч үзнэ үү.

Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ

Батлав.

/САВ ГАЗРЫН ЗАХИРГАА, АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГА /



УС БОХИРДУУЛАГЧ "ЦЭЭГ" ХХК
(ДУРВАН ЭРДЭНЭ ЖУУЛЧНЫ БААЗ)
ЗАХИРАЛ

Л.ЦЭРЭНДОРЖ

ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА БАЙГУУЛАХ УС
БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2011 оны 05 сарын

Дугаар 01

10-ны өдөр

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу

Довсон сумын захиргаа, алаг-эрдэнэ сумын засаг дарга, захиралын -ын гаргасан

/Сав газрын захиргааны дарга эсхүл Сум, дүүргийн Засаг дарга/

2011 оны 05-р сарын 10-ны өдрийн 01 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Довсон сумын захиргаа, алаг-эрдэнэ сумын засаг дарга, захиралын гаргасан

Сав газрын захиргаа, Сум дүүргийн Засаг даргын Довсон сумын захиргаа, алаг-эрдэнэ сумын засаг дарга, захиралын албан тушаалтан Довсон сумын захиргаа, алаг-эрдэнэ сумын засаг дарга, захиралын нөгөө талаас: ус бохирдуулагчийг төлөөлж Цээг ХХК аймаг, нийслэл Улаанбаатар хот, сум, Хан уул дүүрэг 2-р хороо 19-р хороолол баг, хороо70 -р байр 22 тоотод байрлах 9011012058 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 2615843 тоот регистрийн дугаартай Цээг ХХК хуулийн этгээдийг төлөөлж захирал албан тушаалтан Лхагва овогтой Цэрэндорж нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин.Усны чанар.Хаягдал ус.Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харъяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.3.1.Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.3.2.Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.3.Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.4.Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.3.5.Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.3.5.Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно;

3.3.Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгож, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Ус ашиглуулагчийг төлөөлж:
 Э.Забсаа

Ус бохирдуулагчийг төлөөлж:
 ЦЭЭГ ХХК Гурван Эрдэнэ,
 мануульч бааз

/Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын, албан тушаалтны нэр, гарын үсэг/

/Хүн хуулийн этгээдийн албан тушаалтны нэр, гарын үсэг/
 Менежер. Ц.Мянганзүр

Хаяг: Үдэг-Эрдэнэ сум
 311.1


Хаяг: ХУД, 2-р хороо 19-р хороолол 70-22 тоот

Утас: 95114463

Утас: 320320, 99107981, 98706212

(Тамга, тэмдэг):

(Тамга, тэмдэг):
 ХХК



Бохир ус зайлуулах гэрээ

БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭГЧ
Байгаль Эрхэс ХХК-ны
Захирал *[Signature]* /Д.ЦЭЦЭГМАА/
Утас: 9907160, 88108896
ТТ36587 ±5676371



БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

Дугаар № 19/01

Нэг талаас Байгаль Эрхэс ХХК – г төлөөлж Олимп жуулчны баазын гүйцэтгэх захирал С.Ганчимэг, нөгөө талаас "Зөгмт" нсб-н *[Signature]* ажилтай *[Signature]* нар харилцан тохиролцож дараах ажил үйлчилгээг гүйцэтгэхээр гэрээ байгуулж байна.

Нэг.Ерөнхий зүйл

1.1. Байгууллагын бохир усны ариутгах татуургын системийн усыг зайлуулж, халдварт өвчин гарахаас сэргийлж, эрүүл ахуй орчин бүрдүүлэн, зочид гийчид, ажиллагсадын ая тухтай байдлыг хангах зорилгоор энэхүү гэрээг байгуулав.

1.2. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бохир усны ариутгах татуургын системийн шингэнийг сорох, зайлуулах үйлчилгээг нийлүүлэхтэй холбогдуулан гүйцэтгэгч, харилцагчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Хоёр.Бүртгэлийн хэсэг

- 2.1. ААНБ, объектын нэр, регистр..... *"Турван Гурт" жуулчны бааз*
- 2.2. Үйлчилгээний чиглэл, нэр..... *Бичигт адал жуулчлал*
- 2.3. Хаяг. Байршил..... *Совёлол Катгал Овоогой Налаан уул*
- 2.4. Гэрээ хийсэн хүний албан тушаал..... *захирал* нэр..... *А.Цэцэгмаа*
гарын үсэг..... утасны дугаар..... *9840-6212 98111312*

Гурав.Гэрээний хугацаа

3.1. Энэхүү гэрээ нь 2019 оны *07* сарын *01*-ны өдрөөс 20*20* оны *08* сарын *31*-ны өдөр хүртэл " *3* " сар /жил/ хүчинтэй.

3.2. Бохир усны ариутгах татуургын системийн усыг сорох, зайлуулах үйлчилгээг захиалга өгсөний дагуу гүйцэтгэнэ

Дөрөв.Гүйцэтгэгч талын үүрэг, эрх

4.1. Гүйцэтгэгч тал нь гэрээ болон захиалгын дагуу тухайн байгууллагын бохирын ариутгах татуургын системийн шингэнийг зориулалтын машин техникээр соруулж Хатгал тосгоны Харгана гэдэг газрын бохирын цэг дээр зөөж асгана.

4.2. Захиалагч талаас бохирын ариутгах татуургын цооногт байгаа бохир шингэний дотор элдэв төрлийн даавуу, хүүхдийн чивх, эмэгтэй хүний ариун цэврийн хэрэглэл, малын хаягдал үс, арьс, гүзээ, архи, пиво, ундааны лааз, хуванцар сав, шил, гялгар уут зэрэг уусдаггүй овор хэмжээтэй хаягдал байгаа эсэхийг асууж нягтална.

4.3. Тухайн газар очиж бохирын цооногт байгаа шингэний байдалд үзлэг хийж сорох үгүйгээ шийднэ.

4.4. Хэрэв бохирын шингэний талаар худлаа мэдээлэл өгсөн, шаардлага хангахгүй бохирын шингэнийг соруулахгүй бөгөөд автомашины хоосон гүйсэн замын тооцоог төлнө.

4.5. Бохирын автомашин орох гарах гарц чөлөөтэй, бохирын цооногийн амсарын түвшин автомашины бохирын хоолойн түвшнээс доогуур түвшинд байх, бохир соруулахад сорох хоолой чөлөөтэй саадгүй хүрдэг байхыг шаардана.

4.6. Бохирын шингэнийг соруулахдаа цооногийн савны гадуур асгахгүй, орчныг бохир шингэнээр бохирдуулахгүй үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

4.7. Бохирын шингэнийг зайлуулах хөлсийг үйлчилгээ хийсэний дараа шууд бэлэнээр болон 2 хоногийн дотор ХААН банкны С.Ганчимэг гүйцэтгэх захирлын 5015181449 тоот дансанд тушаан төлж барагдуулна.

Тав.Захиалагч талын эрх, үүрэг

5.1. Захиалагч захиалгаа урьдчилж утсаар өгсөний дагуу үйлчилгээг үзүүлнэ.

5.2. Захиалагч тал бохирын шингэний талаарх мэдээлэлээ 4.2-т заасны дагуу үнэн зөв өгнө.

5.3. Гүйцэтгэгч талын үзүүлж буй үйлчилгээг хангалтгүй гэж үзвэл үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг гаргах эрхтэй бөгөөд гүйцэтгэгч тал санал гомдлыг удаа дараа гарган, давтан зөрчил гаргасан тохиолдолд харилцагч гэрээг дангаар цуцлах эрхтэй.

Зургаа.Харилцагч талын эрх, үүрэг

6.1. Энэхүү гэрээнд заасны дагуу харилцагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам үнийн дүнгийн 0.2 хувиар алданги тооцож төлнө.

6.2. Гүйцэтгэгч тал нь уг гэрээнд заасны дагуу харилцагч үйлчилгээ хийгээгүй тохиолдолд нөхөн хийхийг шаардах эрхтэй.

6.3 Энэхүү гэрээ нь талууд газрын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.4 Гэрээнд талууд тохирч нэмэлт өөрчлөлт оруулахдаа бичгээр 2 хувь үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулж гэрээнд хавсаргана. Гэрээнд талуудын оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний үндсэн нөхцөлтэй адил хүчин төгөлдөр байна.

Гүйцэтгэгч байгууллага: "Олссан" нөб
Албан тушаалтан: Доржсүх
Хаяг: Доржсүх Майяа д/н
Утас: 9930-0304

Захиалагч байгууллага: Доржсүх
Албан тушаалтан: Доржсүх
Хаяг: Доржсүх Майяа д/н
Утас: 9940-6212

